

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 3 сарын 23 өдөр

Дугаар 154

Улаанбаатар хот

“Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагчийн
дүрэм”-ийг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Санхүүгийн зохицуулах хорооны Улсын байцаагчийн дүрэм”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Дүрэм шинэчлэн батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 179 дүгээр тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагчийн дүрэм”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА

З.НАРАНТУЯА

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮРЭМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо/цаашид “Хороо” гэх/-ны Улсын байцаагч /цаашид “Байцаагч” гэх/-ийн эрх зүйн байдал, түүний үйл ажиллагааны үндсэн зарчмыг тодорхойлж, санхүүгийн зах зээлийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, Хорооноос гаргасан шийдвэрийг Хорооны зохицуулалтын хүрээнд хамаарах этгээд /цаашид “Хамаарах этгээд” гэх/ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, шалгалт хийхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү дүрэм нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акттай нийцсэн байна.

ХОЁР. Нэр томъёоны тодорхойлолт

2.1. Энэхүү дүрэмд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1. **"Хяналт шалгалт"** гэж санхүүгийн зах зээлийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, Хорооноос гаргасан шийдвэрийг Хамаарах этгээд хэрхэн биелүүлж байгааг дүгнэхэд чиглэсэн хянан шалгах арга хэмжээг;

2.1.2. **"Албан шаардлага"** гэж хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Байцаагчаас хүргүүлсэн, хугацаа зааж гаргасан баримт бичгийг;

2.1.3. **"Шийтгэвэр"** гэж хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг гаргасан ажилтан, албан тушаалтан, хуулийн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хэвлэмэл хуудсаар Байцаагчаас хариуцлага ногдуулсан шийдвэрийг;

ГУРАВ. Байцаагчийн үйл ажиллагааны үндсэн зарчим

3.1. Байцаагч нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, шударга ёсыг эрхэмлэх, бодитой байх, шалгалтыг гагцхүү үндсэн баримтад тулгуурлан хийх, хөндлөнгийн нөлөөнд үл автах, шалгуулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэх, ёс зүйтэй байх зарчмыг баримтална.

3.2. Байцаагч нь ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй асуудлыг хянан шалгаж, шийдвэрлэхээс татгалзана.

3.3. Улсын Ерөнхий байцаагчийн баталсан удирдамжаар Байцаагчийн хяналт шалгалтын зорилго, чиглэл, хугацаа, хүрээ, тодорхойлогдоно.

ДӨРӨВ. Байцаагчийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг

4.1. Байцаагч нь хяналт шалгалтын үйл ажиллагаандаа Холбогдох хууль тогтоомжид зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1 Санхүүгийн зах зээлийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомж болон Хорооноос гаргасан шийдвэрийг Хамаарах этгээд, хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, шалгалт хийнэ;

4.1.2. Хамаарах этгээдийн үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт тавих, шалгалт хийх, хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, таслан зогсоох, холбогдох этгээдэд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах;

4.1.3. Хамаарах этгээд, түүний үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлыг шалгаж, шийдвэрлэх;

4.1.4. Улсын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалтын ажлыг явуулах;

ТАВ. Байцаагчийн эрх зүйн байдал

5.1. Хороо нь Улсын ерөнхий байцаагч, Улсын ахлах байцаагч, Улсын байцаагчтай байх бөгөөд Хорооны дарга Улсын ерөнхий байцаагч, Хорооны гишүүн, Ажлын албаны дарга Улсын ахлах байцаагч байна.

5.2 Энэ дүрмийн 6.1-д заасан шаардлагыг хангаагүй ажилтанд Улсын байцаагчийн эрх олгохгүй.

5.3. Санхүүгийн салбарт хянан шалгалтын чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан ажилтанд энэхүү дүрмийн 6.1.5-д заасан шаардлага хамаарахгүй.

5.4. Байцаагчийн үнэмлэх, тэмдэг болон албан шаардлага, шийтгэврийн хэвлэмэл хуудасны загварыг Улсын ерөнхий байцаагч батална.

ЗУРГАА. Байцаагчид тавигдах шаардлага

6.1. Байцаагч нь хууль тогтоомжид тусгайлан заасан шаардлага болон дараах шаардлагыг хангасан байна.

6.1.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн шалгалт өгч, тангараг өргөсөн;

6.1.2. Хорооны ажилтны ёс зүйн дүрэм, хэм хэмжээг чанд баримталдаг;

6.1.3. Эдийн засагч, санхүүч, нягтлан бодогч, эрх зүйч мэргэжилтэй бөгөөд бакалавраас доошгүй зэрэгтэй;

6.1.4. Хяналт шалгалтын чиглэлээр 2-оос доошгүй жил ажилласан, дадлагажсан, туршлагатай;

6.1.5. Улсын байцаагчийн эрх олгох шалгалтад тэнцсэн;

6.1.6. Сахилгын шийтгэлгүй;

ДОЛОО. Улсын байцаагчийн эрх, үүрэг

7.1. Байцаагч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

7.1.1. Санхүүгийн зах зээлийг зохицуулж буй хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журмыг Хамаарах этгээд хэрхэн биелүүлж байгаад хяналт, шалгалт хийх, хууль тогтоомжид заасан арга хэмжээ, захиргааны шийтгэл ногдуулах, хэрэгжилтийг хянах, үр дүнг хангуулах;

7.1.2. Ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийн үйл ажиллагааг шалгахаас татгалзах;

7.1.3. Байцаагчийн үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг болон албан шаардлага, шийтгэврийн хэвлэмэл хуудас, хэрэглэх;

7.1.4. Хяналт шалгалтын явцад шаардлагатай асуудлыг магадлах, тодорхой мэргэжил, мэргэшлийн дэмжлэг авах, дүгнэлт гаргуулах зорилгоор Улсын байцаагчийн орон тооны бус зөвлөл /”Зөвлөл” гэх/-д хандаж, хяналт шалгалтын ажилд бусад газар /хэлтэс/, болон эрх бүхий байгууллагаар шаардлагатай гэж үзвэл зохих нарийн мэргэшил шаардсан хөндлөнгийн шинжилгээг хийлгэх;

7.1.5. Шаардлагатай гэж үзвэл хяналт шалгалт хийх үедээ холбогдох эрх бүхий байгууллагаар хамгаалуулах тухай Улсын байцаагчийн зөвлөлд хандаж, шийдвэрлүүлэх;

7.1.6. Хяналт шалгалтад саад учруулсан, эсэргүүцсэн, доромжилсон этгээдэд өөрийн эрх хэмжээний хүрээнд болон эрх бүхий байгууллагад хандаж зохих арга хэмжээг авах;

7.1.7. Хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбогдсон санал, гомдлыг Зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;

7.1.8. Хяналт шалгалтыг хууль тогтоомжийн хүрээнд, цаг хугацаанд нь бүрэн гүйцэд, мэргэжлийн түвшинд чанартай хийж гүйцэтгэх;

7.1.9. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг таслан зогсоох, тэдгээрийн шалтгаан нөхцлийг арилгах талаар шалгагдаж байгаа байгууллага, эрх бүхий этгээдэд шаардлага тавих, хугацаатай үүрэг даалгавар өгөх, хэрэгжилтийг хянах, үр дүнг хангуулах арга хэмжээ авах;

7.1.10. Санхүүгийн зах зээлийг зохицуулж буй хууль тогтоомж болон бусад хууль тогтоомжийг Хамаарах этгээд зөрчсөн бол тухайн зөрчлийн шинж байдлыг харгалзан албадлагын арга хэмжээ авах;

7.1.11. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж үзвэл холбогдох баримтыг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, эрх бүхий байгууллагад шилжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлүүлэх;

7.1.12. Хяналт шалгалтын тайлан, гаргасан дүгнэлт, бичсэн танилцуулга, албан шаардлага, шийтгэврийн үндэслэлийг гагцхүү өөрөө хариуцах;

7.1.13. Өөрийн хяналт шалгалт хийсэн ажилтай холбогдох хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүхийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, тайлбар гаргаж өгөх,

7.1.14. Ногдуулсан арга хэмжээ, захиргааны шийтгэлийнхээ хэрэгжилтэд хяналт тавих;

7.1.15. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу ашиг сонирхлын зөрчилтэй эсэх мэдэгдлийг тухай бүр гаргаж, холбогдох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх;

7.1.16. Шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагын хүсэлтээр шинжээчээр ажиллах;

7.1.17. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

7.2. Байцаагч дээр дурьдсан эрх үүргийн хэрэгжүүлэхээс гадна Төрийн албаны тухай хуулийн 13, 14 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан нийтлэг эрх үүргийг мөн адил хэрэгжүүлнэ.

7.3. Улсын ахлах байцаагч энэхүү дүрмийн 7.1, 7.2-д зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

7.3.1. Байцаагчийн үйл ажиллагаа, ажлын гүйцэтгэлд хяналт тавих;

7.3.2. Шаардлагатай тохиолдолд удирдамжид заасны дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаанд биечлэн оролцох;

7.3.3. Хууль, тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

7.4. Улсын ерөнхий байцаагч энэхүү дүрмийн 7.1, 7.2, 7.3-д зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

7.4.1. Зөвлөлийг тэргүүлэх, Байцаагчийн эрх олгох, түдгэлзүүлэх, дуусгавар болгох болон хууль тогтоомжийн хүрээнд Байцаагчийн үйл ажиллагаатай холбоотой бусад шийдвэр гаргах;

7.4.2. Шалгалтын удирдамжийг батлах;

7.4.3. Байцаагчийг бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, бололцоогоор хангах;

7.4.4. Байцаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор давтан сургалт хийлгэх;

7.4.5. Хууль, тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

НАЙМ. Байцаагчийн бүрэн эрхийн баталгаа

8.1. Улсын байцаагчийн бүрэн эрхийн баталгаа, нэмэгдэл олгох журмыг Улсын ерөнхий байцаагч батална.

ЕС. Байцаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл

9.1. Байцаагчид Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйл, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйл, зааснаас гадна дор дурдсан үйл ажиллагааг хориглоно:

9.1.1. Хяналт шалгалтын явцад олж авсан байгууллага, хуулийн этгээд, иргэний нууц бичиг баримт, түүнтэй холбоотой мэдээллийг бусдад дамжуулах, тараах, гаргаж өгөх, хувийн зорилгоор ашиглах;

9.1.2. Хувийн ашиг сонирхлын үүднээс эрх мэдэл, албан тушаалаа хэтрүүлэх, урвуулан ашиглах;

9.1.3. Хяналт шалгалт дуусаагүй, эцсийн дүгнэлт гараагүй байхад урьдчилан дүгнэлт гаргах, мэдээ, мэдээлэл тараах, түүнийгээ батлах зорилгоор шалгалтыг үргэлжлүүлэн хийх, хууль бус үйлдлийг нуун дарагдуулах;

9.1.4. Шалгалтын материалыг бодит байдлаас санаатайгаар зөрүүтэй бичих, хяналт шалгалтын танилцуулга, дүгнэлтийг гуйвуулах, аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэх;

9.1.5. Шалгалт хийх, танилцуулга, дүгнэлт бичих, арга хэмжээ авах, албан шаардлага үйлдэх, шийтгэвэр ногдуулахдаа бусдын нөлөөнд автах, авлига авах;

9.1.6. Байцаагчийн үнэмлэх, албан шаардлага, шийтгэврийн хуудсыг хууль бус үйл ажиллагаанд ашиглах, устгах, хуурамчаар үйлдэх болон тэдгээрийг бусад этгээдэд ашиглах боломж олгох;

9.1.7. Шалгагдаж буй байгууллага, хуулийн этгээдээс зээл авах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө ажил үйлчилгээг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдан авах, түрээслэх, үйлчлүүлэх;

9.1.8. Байцаагч нарт хийж байгаа хяналт шалгалттай холбогдуулан дарамт шахалт үзүүлэх, хөндлөнгөөс нөлөөлж тайлан, дүгнэлт гаргуулах, албан шаардлага, шийтгэвэр үйлдүүлэх;

9.1.9. Хамаарах этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, гүйцэтгэх удирдлага, тэдгээртэй адилтгах зөвлөлийн гишүүн байх;

9.1.10. Бүрэн эрхийн хүрээнээс гадуур зүйл шаардах;

9.1.11. Хууль тогтоомжоор хориглосон бусад үйл ажиллагаа явуулах.

АРАВ. Байцаагчийн үйл ажиллагаанд тавих хяналт

10.1. Байцаагчийн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдсон харилцааг Зөвлөлийн ажиллах журмаар зохицуулна.

АРВАН НЭГ. Байцаагчийн эрх олгох, түдгэлзүүлэх, дуусгавар болгох

11.1. Байцаагчийн бүрэн эрхийг дараах тохиолдолд түдгэлзүүлнэ.

11.1.1. Хуулийн байгууллагаас шалгагдаж байгаатай нь холбогдуулан хүсэлт ирүүлсэн;

11.1.2. Байцаагчид холбогдох гомдол, зөрчлийг Зөвлөлөөр хэлэлцээд шийдвэр гаргасан;

11.1.3. Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу түр чөлөөлөгдсөн;

11.1.4. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр.

11.2. Байцаагчийн эрх дараах тохиолдолд дуусгавар болно.

11.2.1. Хяналт шалгалтын бус чиг үүргийг хэрэгжүүлэх ажил, албан тушаалд томилогдсон;

11.2.2. Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, Хорооны ёс зүйн дүрэм, энэхүү дүрмийн 9 дүгээр зүйлд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлсэн нь нотлогдсон;

11.2.3. Өөр ажил, албан тушаалд томилогдсон, ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн;

11.2.4. Албан үүргээ хангалтгүй биелүүлсэн буюу албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашигласан;

11.2.5. Байцаагчийн эрх олгох шалгалтанд тэнцээгүй.

АРВАН ХОЁР. Байцаагчаас авах арга хэмжээ, ногдуулах захиргааны шийтгэл

12.1. Байцаагч хяналт шалгалтын дүнгийн талаар шалгалт дууссанаас хойш Удирдамжид заасан хугацаанд шалгалтын тайлан, дүгнэлтийг Улсын ахлах болон Улсын ерөнхий байцаагчид танилцуулна.

12.2. Хяналт шалгалтын тайланд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 26.1 хэсэг, шалгалтын удирдамжид заасныг тусгаж, 2 хувь үйлдэж гарын үсэг, тэмдэг дарж баталгаажуулан шалгуулсан байгууллагын эрх бүхий албан тушаалтанд танилцуулж, хувийг өгнө.

12.3. Тухайн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан хяналт шалгалтын тайланд гарын үсэг зурахаас татгалзсан, эсхүл татгалзсан шалтгааны талаар бичгээр тайлбар өгөхгүй байх нь шалгалтын тайланг хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэл болохгүй.

12.4. Байцаагч нь хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, таслан зогсоох, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хугацаатай үүрэг даалгавар өгөх зэрэг бүрэн эрхийнхээ хүрээнд албан шаардлага хүргүүлнэ.

12.5. Байцаагчийн албан шаардлагад дараах зүйлийг тусгана:

12.5.1. Зөрчил гаргасан он, сар өдөр, холбогдох этгээдийн нэр хаяг;

12.5.2. Илрүүлсэн зөрчлийн товч утга, зөрчсөн хууль тогтоомж;

12.5.3. Хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар өгсөн үүрэг даалгавар, хариу мэдэгдэх хугацаа болон түүнийг тогтоосон хугацаанд эс биелүүлбэл дараагийн арга хэмжээ авах талаар заах;

12.6. Байцаагч дараах тохиолдолд шийтгэврийн хуудсаар торгууль ногдуулж болно;

12.6.1. Байцаагч албан шаардлагыг үндэслэн;

12.6.2. Шийтгэвэр ногдуулахдаа зөрчил үүссэн шалтгаан, шинж байдал, агуулга, хэлбэр, хохирлын хэмжээ, сөрөг нөлөөлөл, зөрчил арилсан эсэх зэрэг хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан холбогдох хууль, тогтоомжийн дагуу бие даан шийдвэрлэх;

12.7. Шийтгэврийн хуудсаар торгууль ногдуулахад хуульд заасан хэмжээг мөрдөх бөгөөд тогтоосон хэмжээг багасгаж үл болно.

12.8. Зөрчил гаргасан этгээд Байцаагчийн тавьсан албан шаардлага, шийтгэвэрийг үндэслэлгүй гэж үзвэл Улсын байцаагчийн тавьсан албан шаардлага, шийтгэвэрийг хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор Зөвлөлд гомдол гаргаж болно.

12.9. Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн гаргасан Улсын ерөнхий байцаагчийн шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд хандаж болно.

12.10. Улсын байцаагчаас өгсөн албан шаардлага, зөрчлийн тухай тэмдэглэлийн бүртгэлийг Үйл ажиллагааны газар нэгтгэн хөтөлж, дугаарлана.

АРВАН ГУРАВ. Байцаагчийн авсан арга хэмжээ, ногдуулсан захиргааны шийтгэлийн хэрэгжилтийг хангах

13.1. Байцаагчаас ногдуулсан шийтгэврийг эрх зүйн зөрчил гаргасан хуулийн этгээд, холбогдох ажилтан албан тушаалтан хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор холбогдох дансанд шилжүүлнэ.

13.2. Энэ дүрмийн 13.1 дэх хэсэгт заасан зөрчил гаргагч нь тогтоосон хугацаанд торгуулийг төлөөгүй бол Захиргааны хариуцлагын тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай

хуулийн дагуу Байцаагч шийдвэрлүүлж, төлүүлэх бөгөөд холбогдон гарсан зардлыг хариуцлага хүлээсэн этэгээдээр төлүүлнэ.

13.3. Зөвлөлөөс Байцаагчийн албан шаардлага, ногдуулсан арга хэмжээ, захиргааны шийтгэлийг өөрчилж шийдвэрлэсэн нь хууль тогтоомж зөрчсөн болохыг нотолсон тохиолдолд эдгээр акт, мэдэгдэл, оногдуулсан арга хэмжээ, захиргааны шийтгэлээс үүдэн гарах хариуцлага тухайн Байцаагчид хамаарахгүй.

13.4. Байцаагчийн тогтоосон албан шаардлага, шийтгэврийг шалгуулагч этгээд эс зөвшөөрөх нь Улсын байцаагчийн албан шаардлага, шийтгэврээр хүлээх хариуцлагаас чөлөөлөгдөх, биелүүлэхээс татгалзах үндэслэл болохгүй.

**АРВАН ДӨРӨВ. Байцаагч хэвлэмэл хуудас,
хувийн дугаар бүхий тэмдэг хэрэглэх,
эргүүлэн тушаах**

14.1. Үйл ажиллагааны газар нь Байцаагчийн шийтгэврийн хэвлэмэл хуудсыг батлагдсан маягтын дагуу хэвлүүлж, нэг удаагийн үнийг тогтоох ба тооцооны нягтлан бодогч энэхүү үнэт цаасыг холбогдох журмын дагуу данс бүртгэлд тусгана.

14.2. Үйл ажиллагааны газар Байцаагчийн эрх олгогдсон ажилтанд энэ тухай шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногийн дотор Байцаагчийн үнэмлэх, шийтгэврийн хэвлэмэл хуудас, хувийн дугаар бүхий тэмдгийг олгоно.

14.3. Байцаагч нь үрэгдүүлсэн үнэмлэх, тэмдэг, шийтгэврийн хуудас, болон залруулан бичсэн шийтгэврийн хуудас, албан шаардлага, шийтгэврийн тайланг энэхүү дүрмийн хавсралтын дагуу гаргаж, Үйл ажиллагааны газрын ажилтанд гаргаж өгнө.

14.4. Байцаагчийн эрхийг түдгэлзүүлсэн, дуусгавар болгосон бол энэ тухай мэдэгдлийг холбогдох ажилтанд Үйл ажиллагааны газар нь ажлын 3 хоногийн дотор мэдэгдэнэ. Мэдэгдэл хүлээн авсан ажилтан ажлын 3 хоногийн дотор Байцаагчийн үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг, хэрэглэгдсэн шийтгэврийн хэвлэмэл хуудасны тайлан, хэрэглэгдээгүй үлдсэн хувийг тодорхой хугацаагаар тасалбар болгон хүлээлгэн өгч, холбогдох тооцоог дуусгавар болгоно.

АРВАН ТАВ. Байцаагчид хүлээлгэх хариуцлага

15.1. Энэ дүрмийг зөрчсөн Улсын байцаагчид бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----ooOoo-----

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ УЛСЫН БАЙЦААГЧ АЛБАН ШААРДЛАГА,
ШИЙТГЭВРИЙГ ЗАЛРУУЛАН БИЧСЭН ТУХАЙ ТАЙЛАН

Улсын байцаагчийн нэр: _____

Улсын байцаагчийн тэмдгийн хувийн дугаар: _____

Улсын байцаагчийн үнэмлэхийн дугаар: _____

Огноо: _____

Албан шаардлага

дд	Залруулан бичсэн албан шаардлагын дугаар, огноо	Дахин бичсэн албан шаардлагын дугаар, огноо	Залруулан бичих болсон тухай тайлбар

Шийтгэврийн хуудас

дд	Залруулан бичсэн шийтгэврийн хуудасны дугаар, огноо	Дахин бичсэн шийтгэврийн хуудасны дугаар, огноо	Залруулан бичих болсон тухай тайлбар

Нийт залруулан бичсэн шийтгэврийн хуудасны тоо:

Тайлан гаргасан:

Улсын байцаагч (Нэр, гарын үсэг, тэмдэг)

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОХООНЫ УЛСЫН БАЙЦААГЧИЙН ҮРЭГДҮҮЛСЭН
ХЭВЛЭМЭЛ ХУУДАС, ТЭМДЭГ, ҮНЭМЛЭХИЙН ТАЙЛАН

Улсын байцаагчийн нэр: _____
Улсын байцаагчийн тэмдгийн хувийн дугаар: _____
Улсын байцаагчийн үнэмлэхийн дугаар: _____
Үрэгдүүлсэн огноо: _____

Бичсэн хэвлэмэл хуудаст хамаарах:

дд	Албан шаардлага /дугаарын хамт/	Шийтгэврийн тоо /дугаарын хамт/

Үрэгдүүлсэн нөхцөл байдлын тухай тайлбар: _____

Тайлан гаргасан:
Улсын байцаагч (Нэр, гарын үсэг, тэмдэг)

